

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/01/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulzii@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/128

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ОТГОНЧУЛУУН
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020231

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,866,609.00	2,164,610.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,866,609.00	2,164,610.00
35400	Хангамжийн материал	2,866,609.00	2,164,610.00
35410	Бичиг хэргийн материал	954,900.00	938,000.00
35420	Аж ахуйн материал	612,409.00	788,310.00
35440	Түлш, шатах тослох материал	890,000.00	
35470	Бусад хангамжийн материал	409,300.00	438,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	139,713,835.89	117,372,439.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	139,713,835.89	117,372,439.25
392	Биет хөрөнгө	139,713,835.89	117,372,439.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,375,000.00	80,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,375,000.02)	(12,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	96,105,791.09	87,292,541.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,782,195.04)	(38,229,381.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,714,493.00	5,714,493.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,324,253.14)	(5,405,213.06)
393	Биет бус хөрөнгө	73,219,582.78	73,160,000.00
39301	Программ хангамж	520,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(520,000.00)	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	142,580,444.89	119,537,049.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	142,580,444.89	119,537,049.25
51	Засгийн газрын хувь оролцоо	142,580,444.89	119,537,049.25
51200	Хуримтлагдсан үр дүн	142,580,444.89	119,537,049.25
51210	Өмнөх үеийн үр дүн	48,230,657.37	142,580,444.89
51220	Тайлант үеийн үр дүн	94,349,787.00	(23,043,395.64)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	142,580,444.89	119,537,049.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	499,148,705.00	382,832,406.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,551,786.00	709,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	980,770,534.66	13,275,250.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	107,814,986.00	
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	736,800.00	709,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,596,919.00	382,122,506.00
1310	Улсын төсвөөс	116,987,700.00	195,843,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	116,987,700.00	195,843,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	273,609.219.00	186,278,706.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	273,609.219.00	186,278,706.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	404,798,917.48	405,875,801.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,798,917.48	405,875,801.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,386,109.48	368,719,086.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,251,793.50	172,991,487.37
210101	Үндсэн цалин	117,389,923.50	98,812,885.53
210102	Нэмэгдэл	17,612,402.00	60,806,793.60
210103	Унаа хоолны хөнгөлт	3,558,000.00	9,264,000.00
210104	Урамшуулал	4,691,468.00	4,107,808.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,734,723.50	21,567,506.15
210201	Тэтгэврийн даатгал	12,780,378.00	15,238,337.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,355,346.00	1,603,115.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,067,477.22	1,269,291.10
210204	Ажилгүйдлийн даатгал	230,138.24	314,250.76
210205	Эрүүл мэндийн даатгал	2,301,384.04	3,142,511.56
2104	Хангамж, бараа материалын зардал	38,757,910.00	17,189,189.00
210401	Бичиг хэрэг	4,687,100.00	1,971,350.00
210402	Тээвэр, шатахуун	32,740,000.00	13,493,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	988,210.00	792,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	342,600.00	932,549.00
2107	Томилолт, зочны зардал	31,973,000.00	32,028,000.00
210702	Дотоод албан томилолт	31,973,000.00	32,028,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,471,184.00	83,691,359.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	142,251,304.00	82,945,579.48
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	689,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,280.00	34,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	14,800.00	22,00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,197,498.48	41,251,544.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		18,910,148.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	10,197,498.48	22,341,396.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,412,808.00	37,156,715.00

Төв аймгийн Засаг Даргын Дэргэдэх Статистикийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,216,008.00	24,504,779.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,216,008.00	24,504,779.08
2135	Төсвийн захирагчдаас олгох санхүүжилт, шилжүүлэг		12,151,935.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		12,151,935.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	94,349,787.52	(23,043,395.64)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	94,349,787.52	(23,043,395.64)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			48,230,657.37	48,230,657.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			48,230,657.37	48,230,657.37
Тайлант үеийн үр дүн			94,349,787.52	94,349,787.52
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			142,580,444.89	142,580,444.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			142,580,444.89	142,580,444.89
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			(23,043,395.64)	(23,043,395.64)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			119,537,049.25	119,537,049.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	390,596,919.00	382,122,506.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	390,596,919.00	382,122,506.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,596,919.00	382,122,506.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	116,987,700.00	195,843,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	116,987,700.00	195,843,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	273,609,219.00	186,278,706.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	273,609,219.00	186,278,706.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	390,596,919.00	382,122,506.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,596,919.00	382,122,506.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,184,111.00	344,965,791.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,086,227.00	172,991,487.77
210101	Үндсэн цалин	117,224,357.00	98,812,885.53
210102	Нэмэгдэл	17,612,402.00	60,806,794.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,558,000.00	9,264,000.00
210104	Урамшуулал	4,691,468.00	4,107,808.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,734,724.00	21,567,506.15
210201	Тэтгэврийн даатгал	12,780,378.00	15,238,337.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,355,346.48	1,603,115.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,067,477.24	1,269,291.10
210204	Ажилгүйдлийн даатгал	230,138.24	314,250.75
210205	Эрүүл мэндийн даатгал	2,301,384.04	3,142,511.56
2104	Хангамж, бараа материалын зардал	33,043,310.00	14,331,290.00
210401	Бичиг хэрэг	207,000.00	1,892,450.00
210402	Тээвэр,шатахуун	31,340,000.00	11,248,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,063,210.00	792,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	370,100.00	398,500.00
2107	Томилолт, зочны зардал	31,496,000.00	31,004,000.00
210702	Дотоод албан томилол	31,496,000.00	31,004,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,568,750.00	95,360,859.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,599,870.00	93,881,579.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	689,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,280.00	34,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	14,800.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	425,000.00	733,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,100.00	9,710,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,710,648.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	255,100.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,412,808.00	37,156,715.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	500,000.00

Төв аймгийн Засаг Даргын Дэргэдэх Статистикийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгох санхүүжилт, шилжүүлэг	16,370,508.00	24,504,779.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,370,508.00	24,504,779.08
2135	Төсвийн захирагчдаас олгох санхүүжилт, шилжүүлэг	3,845,500.00	12,151935.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,845,500.00	12,151935.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,843,800.00	195,843,800.00		100.00%
УРСГАЛ ЗАРДАЛ	195,843,800.00	195,843,800.00		100.00%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,843,800.00	170,839,020.92	24,504,779.08	87.46%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,593,800.00	149,684,145.77	19,909,654.23	88.26%
Үндсэн цалин	110,045,000.00	82,016,885.53	28,028,114.47	74.53%
Нэмэгдэл	39,372,100.00	54,295,452.00	(14,923,352.00)	137.90%
Унаа хоолны хөнгөлөлт	10,239,600.00	9,264,000.00	975,600.00	90.47%
Урамшуулал	9,937,100.00	4,107,808.24	5,829,291.76	41.34%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	21,199,300.00	18,877,255.15	2,322,044.85	89.05%
Тэтгэврийн даатгал	14,415,500.00	12,870,191.62	1,545,308.38	89.28%
Тэтгэмжийн даатгал	1,695,900.00	1,514,140.53	181,759.47	89.28%
ҮОМШӨ-ний даатгал	1,356,800.00	1,198,111.86	158,688.14	88.30%
Ажилгүйдлийн даатгал	339,200.00	299,527.67	39,672.33	88.30%
Эрүүл мэндийн даатгал	3,391,900.00	2,995,283.47	396,616.53	88.31%
Хангамж, бараа материалын зардал	2,298,800.00	1,478,840.00	819,960.00	64.33%
Бичиг хэрэг	500,000.00		500,000.00	00.0
Тээвэр,шатахуун	600,000.00	548,000.00	52,000.00	91.33%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	532,290.00	267,710.00	66.54%
Бага дүнтэй, түргэн элэгдэх ахуйн зүйл	398,800.00	398,550.00	250.00	99.94%
Эд хогшил, урсгал засварын зардал	266,500.00		266,500.00	00.0
Урсгал засвар	266,500.00		266,500.00	00.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,485,400.00	769,780.00	715,620.00	51.82%
Даатгалын үйлчилгээ	689,500.00	689,500.00		100%
Тээврийн хэрэгслийн татвар	39,200.00	34,280.00	4,920.00	87.45
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00		100%
Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	734,700.00	24,000.00	710,700.00	3.27%
Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	29,000.00	471,000.00	5.80%
Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	29.00	171,000.00	14.50%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00		300,000.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		24,504,779.08	(24,504,779.08)	100%
Төсвөөс санхүүжих		500,00.00	500,000.00	100%
АЖИЛЛАГСДЫН ТОО	7	7		100%
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	4	4		100%
Үйлчлэх ажилтан	2	1		50%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	186,278,706.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,278,706.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,126,770.08
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	23,307,342.00
210201	Үндсэн цалин	16,796,000.00
210102	Нэмэгдэл	6,511,342.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,690,251.00
210201	Тэтгэврийн даатгал	2,368,146.05
210202	Тэтгэмжийн даатгал	88,974.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,179.24
210204	Ажилгүйдлийн даатгал	14,723.08
210205	Эрүүл мэндийн даатгал	147,228.09
2104	Хангамж, бараа материалын зардал	12,852,450.00
210401	Бичиг хэрэг	1,892,450.00
210402	Тээвэр, шатахуун	10,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,000.00
2107	Томилолт, зочны зардал	31,004,000.00
210702	Дотоод албан томилолт	31,004,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,591,079.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	93,881,579.08
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	709,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,681,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,681,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,151,935.92
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,151,935.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,151,935.92
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,830,089.06
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,830,089.06
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	186,278,706.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	186,278,706.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,278,706.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	186,278,706.00
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд орших чиг үүрэг бүхий Үндэсний Статистикийн хорооны харьяа байгууллага

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын 14 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 94,43 %-тай дүгнэгдсэн байна

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, багийн Засаг дарга гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд хэлтсийн дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3, үйлчилгээний ажилтан 2, гэрээтээр 3 бүгд 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Статистикийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2018 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн Үндэсний Статистикийн хорооны даргын А/162 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй болно.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,043.4 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	2,886.60	2,164.4	(721.6)
Үндсэн хөрөнгө	139,713.8	117,372.4	(22,341.8)
Нийт хөрөнгө	142,580.4	119,537.0	(23,043.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	142,580.4	119,537.0	(23,043.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	142,580.4	119,537.0	(23,043.4)

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны үлдэгдэл 721.6 мянган төгрөгөөр буурсан хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн, шаардлагагүй бараа материал нөөцлөөгүйтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансанд 2023 оны байдлаар авто тээврийн хэрэгсэл 29,375.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 8,813.2 мянган төгрөг, программ хангамж 520.00 мянган төгрөг, нийт 38,708.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 119,537.0 мянган төгрөг болж 23,043.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 169,054.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 26,789.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 195,843.8 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 195,843.8 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 195,843.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 195,843.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 24,504.7 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 171,339.0 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байна.

Дээд шатны байгууллагаас 195,843.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулаагүй үлдэгдэл 12,151.9 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	70405- Албан ёсны статистик				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	195,343.8	170,839.0	24,504.8	88.0%
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэж, урамшуулал.	500.0	500.0	0	100.0%
	Дүн	195,843.8	171,339.0	24,504.8	87.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэхүү тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 186,278.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын зардалд 25,997.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 12,852.5 мянган төгрөг, томилолтын зардалд 31,004.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 94,591.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 9,681.7 мянган төгрөг зарцуулжээ.

Дээд шатны байгууллагаас 195,843.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулаагүй үлдэгдэл 12,151.9 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэхүү тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд байгууллага нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22 -ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 432,710.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,490.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,868.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус хэлтэс нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, хангамж бараа материалын зардал 819.9 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 266.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 715.6 мянган төгрөг, нийт 1,802.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 157 мэдээллийг хуулийн хугацаанд, 2 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 20 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	890.0	1	890.0	100%
Нийт дүн	2	890.0	2	890.0	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистик хэлтэс дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 457,116.4 мянган төгрөгийн алдаа, ¹илэрснээс аудитын явцад 457,116.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг өмнөх онтой зэрэгцүүлэн бэлтгэж тайлагнаагүй 438,806.2 мянган төгрөгийн алдаа УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг 18,310.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар 5,293.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 5,293.1 мянган төгрөгийн 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1 Албан шаардлага

Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ"; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үлдэх өртөггүй хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн санхүүгийн тайланд 4,630.2 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэсэн байгаа нь УСНББОУС 17.44-т "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1. Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.

Өгсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, бүртгэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.

2. ХХОАТ-ын тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин хөлснөөс суутгасан ХХОАТ-ын суутгалыг 662.9 мянган төгрөгөөр зөрүүтэй суутгасан байна. Энэ нь УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах"

Өгсөн зөвлөмж: Цалин хөлснөөс суутгах суутгалыг хуулийн дагуу суутган үнэн зөв тайлагнан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг өмнөх онтой зэрэгцүүлэн бэлтгэж тайлагнаагүй	1	438,806.2	1	438,806.2			1	438,806.2				
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	18,310.2			1	18,310.2	1	18,310.2				
Дүн	2	457,116.4	1	438,806.2	1	18,310.2	2	457,116.4				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлээгүй.	1	4,630.2					1	4,630.2				
Цалин хөлснөөс суутгасан ХХОАТ-ыг буруу тооцон суутгасан	1	662.9					1	662.9				
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүй	1	-							1	-		
Дүн	3	5,293.1					2	5,293.1	1	-		



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар _____

96-17225502-ТӨА-2024/01/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Ц.Цэндсүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга Ж.Отгончулуун, нягтлан бодогч Ц.Цэндсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ